

“БНХАУ-ЫН ШИНЭЧЛЭЛ ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЭ МӨЧЛӨГ”

Жао Цижэн*

Хүндэт гэг сайг Чулуунбат аа!

Хүндэт Баяр захирал аа!

Ноёд хатагтай та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая.

Миний бие Монгол Хятадын харилцаа болон Хятадын шинэ хөгжил дэвшлийн талаар та бүхэнтэй санал бодлоо солилцохоор өөрийн жижиг багийг дагуулан Монгол улсад хүрэлцэн ирэх боломжтой болсондоо маш их баяртай байна. Би урьд нь Хятадын өөрчлөлт нээлттэй бодлогын бүхий л үйл явцад оролцож байсан боловч нас сүүдэр дээр гарсны улмаас тэргүүн шугаманд ажиллалгүй өнөө жилээс эхлэн арай хөнгөн ажил дээр очоод байгаа юм.

Өнгөрсөн оны 11 сард хуралдсан Хятадын Коммунист намын 18 дугаар их хурлаас шинэ удирдах бүрэлдэхүүнийг сонгон гаргасан билээ. Урьд өмнөх үетэй харьцуулбал энэ удирдах бүрэлдхүүнд маш их өөрчлөлт ажиглагдаж байна. Миний бие Шанхай хотын намын хорооны гишүүн, Шанхай хотын удирдлагад ажиллаж байх үед манай улсын удирдах бүрэлдхүүнд багтсан хүмүүсийн боловсролын түвшин харилцан адилгүй буюу тухайлбал ердийн их сургууль төгссөн, Орост суралцаж байсан төдийгүй их сургуулийн мэдлэг боловсрол эзэмшээгүй хүн ч байдаг л байсан. Гэтэл сая сонгогдсон удирдах бүрэлдхүүний байдлыг харж байхад бүгд их сургуулийн чамбай боловсролтой төдийгүй гадаадад суралцаж төгссөн хүн олон байгаа юм. Өөр нэг том ялгаатай тал гэвээс урьд өмнөх ХКН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдийн дунд байгалийн болон инженерийн боловсролтой хүмүүс зонхилж

*Жао Цижэн - 11 дэхь удаагийн Бүх Хятадын Улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Гадаад харилцааны хорооны дарга, Ардын Их Сургуулийн Хэвлэл мэдээллийн сургуулийн захирал

байсан. Үүнд хоёр учир шалтгаан байгаагийн нэг нь юу гэвэл тухайн цаг үед их сургуулиуд энэ хоёр чиглэлээр голчлон оюутан элсүүлэхээс биш, хуулийн болоод эдийн засгийн мэргэжлээр маш цөөн тооны оюутан элсүүлдэг байсантай холбоотой юм.

Учир нь тухайн цаг үед төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой байсан болохоор төдийлөн олон тооны хүмүүс шинийг бүтээх шаардлагагүй. Засгийн толгойд хамаг ачаа оногддог байсан тул түүний үгийг сонсоод байхад болно гэдэг утгаар эдийн засагчдын тоо ер нь л цөөхөн байсан хэрэг.

Ганцхан төлөвлөгөөний хороо нийт улс орны бизнес эрхлэгчдийн сэтгэлгээг төлөөлнө гэдэг мэдээжийн хэрэг боломжгүй зүйл билээ. Хятадын хувьд гамшигт тооцогддог соёлын их хувьсгалын дараа ахмад албан тушаалтан болон кадр ажилтны дийлэнх нь далаас дээш насныхан байсан тул чадалтай залуучуудыг татан гаргаж ирэх онцгой хэрэгцээ шаардлага урган гарсан. Гэвч харьцангуй өндөр боловсролтой гэгддэг залуучуудын дийлэнх буюу ер орчим хувь байгалийн болоод техникийн чиглэлээр сурч төгссөн байлаа. Тийм болохоор би хэдийгээр физикийн мэргэжил эзэмшсэн боловч улс төрийн ажилд татагдан орсон нь тухайн цаг үеийн онцлог хэв шинжийг харуулж байгаа хэрэг юм. Зян Зөминь, Жу Рунзи нар ч гэсэн электрон техникийн мэргэжлээр суралцаж төгссөн хүмүүс билээ. Харин саяхан шинээр сонгогдсон удирдах бүрэлдэхүүний дотор цорын ганц хүн л инженер техникийн чиглэлээр төгссөн бөгөөд бусад нь бүгд хэл бичиг, эдийн засаг болон хуулийн чиглэлээр боловсрол эзэмшсэн хүмүүс байгаа нь цаг үеийн шаардлагад нийцэж байна. Хятад улс бүх талын бүтээн байгуулалт, хөгжлийн үе рүүгээ орж байгаа болохоор гагцхүү байгаль техникийн ухааны хүмүүст түшиглээд хангалтгүй гэдэг нь тодорхой. Сүүлийн нэг жилийн хугацаанд манай шинэ удирдлагын тулгуур баримтлал, удирдах арга барил болон тэдгээрийн олсон амжилт нь хятадын ард түмний өргөн хүрээлэл дэмжлэгийг олоод байна. Саяхан хуралдсан 18 дахь удаагийн гуравдугаар бүгд хурал нь шинэ удирдлагын зүгээс шийдвэртэй, зоримог өөрчлөх концепцийг батлан гаргасан нь Хятад улсын хувьд маш чухал нөлөөтэй хэрэг юм. Гуравдугаар бүгд хурлаас

шинэ удирдах бүрэлдэхүүний өөрчлөлтийн концепци болон шийдвэр зоригийг илэрхийлэн гаргасан нь бүх талаар өөрчлөн шинэчлэх нь гэдгийг батлан харуулж байна. Бүгд хурлын албан мэдээ л гэхэд 60 зүйлтэй байгаа. Өнөөдөр би та бүхэнд түүний гол агуулгыг танилцуулъя гэж бодож байна.

Бидний урьд өмнө туулж ирсэн үйл явц хүндрэл бэрхшээлтэй тулгарсан болохоор бүх талын гүн гүнзгий өөрчлөлтийг явуулахаас өөр аргагүй болоод байна. Хятад улс өөрчлөлт нээлттэй бодлогыг хэрэгжүүлээд 35 жил болохдоо уламжлалт төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн боловч бид бүхэн муужруулах эмчилгээний аргыг авч хэрэгжүүлээгүй, харин ч хашир атлаа хурдан түргэн, тулхтай өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Өөрчлөлтийн эхэн үед Дэн Сяопин урьдын ангийн тэмцлийг гол болгох бодлогын оронд эдийн засгийн хөгжлийг голчлох зорилт дэвшүүлсэн нь Хятад улсын хувь заяанд онцгой нөлөө бүхий чухал хувиралт болсон. Олон улсын нөхцөл байдлын тал дээр авч үзвэл хүйтэн дайны орчноос ангижирч, эдийн засгийн бүтээн байгуулалтад хамаг эрч хүчээ чиглүүлэх боломж бүрдсэн билээ. Гэвч бидэнд туршлага дутмаг байсан болохоор аргазүйн онолын хувьд Дэн Сяопин дарга ардын зүйр үгнээс улбаатай товч ухагдахуун болох «Чулуу тэмтрэн гол гатлах» гэсэн үгийг авч хэрэглэжээ. Яагаад гэвэл бусад улсын хувьд манай өөрчлөлтөд үлгэр болчихоор загвар байгаагүй. Хятад шиг өргөн уудам нутаг дэвсгэртэй, маш их асуудал хуралдсан, үй олон хүн амтай улсын хувьд бусдын бэлэн зэхээний туршлагыг шууд хуулбарлан хэрэглэх нь боломжгүй хэрэг л дээ. Тэрхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд боловсон хүчний тал дээр мухар сохор биш атлаа тэгтлээ айж бэмбэгнээд байх шаардлагагүй байсан юм. Тийм ч учраас Дэн Сяопин дарга эр зориг хашир хэрсүүг уялдуулах хэрэгтэй гэж хэлж байсан удаатай. Гэхдээ энэ нь тийм ч амар уялдаа зохицол байгаагүй. Хэт зоримог байх гэвэл гоомой хөдлөчих гээд, дэндүү хашир байна гэвэл хуучинсаг байдалд автах биш үү? Миний бие Хятадын олон тооны удирдах боловсон хүчний нэгэн адил хилийн дээс алхаж, Европ, Америк болон Зүүн Европ, Орос орны байр байдалтай биечлэн танилцаж байв.

Зүүн Европын улсуудын тухайд манай Хятадтай адилхан Зөвлөлт маягийн төлөвлөгөөг эдийн засагтай байсан. Тэд нар түүнийг хэрхэн өөрчлөх явцдаа амжилт, ялагдлын алинтай учирч байгааг бид маш анхааралтай ажиглан судлаж байв. Өнгөрсөн 35 жилийн хугацаанд бид бүхэн маш түргэн хурдацтай хөгжиж, дэлхийн хоёрдахь том эдийн засгийг байгуулж чадсан нь зарим талаар манай хятадуудын төсөөлж байгаагүй хэрэг юм. Гэвч түүний хажуугаар шинэ асуудлууд үүсэн гарч байгаагийн дотор эдийн засгийн бүтэц тэнцвэргүй, зарим үйлдвэрлэлийн салбарын бүтээмж хэт илүүдэлтэй байна.

Тухайлбал: Ган, химийн аж үйлдвэр, цемент, салхин цахилгаан станц болон катодын хөнгөн цагаан зэрэг бүтээгдхүүнийг дурьдаж болох юм. Мөн орон нутгийн удирдах байгууллагын өр зээл харьцангуй их буюу 3 их наяд ам долларын түвшинд хүрээд байна. Энэ нь Америк болон Европын улс орнуудын дээрх үзүүлэлттэй харьцуулбал шалихгүй тоо бөгөөд нөгөө талаас дотоодын зээл гэдгийг бодолцвол эрсдэлийн хувьд тийм ч өндөр биш юм. Тухайлбал япон улсын өрийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээнээс 2 дахин даван гарсан боловч Европ Америкийн улсуудтай харьцуулбал бас л гайгүй гэж үздэг. Учир нь тэр бол дотоод зээл бөгөөд гадаад зээл биш ажээ.

Хятадын нийгмийн хамгааллын түвшин харьцангуй доогуур, олон түмэн маш арвич хямгач болохоор иргэдийн хадгаламжийн хэмжээ 50 хувийг даваад байгаа нь дэлхийд ховорхон үзүүлэлт юм. Энэ нь хятадын банкиг баяжуулж, зээл олгох өргөн боломжийг олгож байгаа боловч хятадын дотоод зах зээлийн хэрэглээ түүнийг багтаах чадамж тааруу байна. Бидний мэдэж байгаачлан дэлхийн бусад улсын хүн амын хадгаламжийн хэмжээ сайндаа л 20 хувьтай байдаг бол Америкийнх бүр 2-хон хувьтай байдаг шүү дээ. Өөрөөр хэлбэл америкууд зээл авч хэрэгцээгээ хангадаг бол манай хятадууд мөнгөө хадгалчихаад хэрэглэж чадахгүй байна гэсэн үг. Америкийн гуч гарсан залуу хүн банкнаас мөнгө зээлчихээд сайхан байранд амьдарч болдог бол манай хятадын 50 настай хүн байр авах мөнгөө банкинд хадгалчихаад байлгаад байдаг. Гэтэл бид америкийн бондыг худалдан аваад байгаа нь бас

л нэг сонин хэрэг л дээ. Энэ нь хятадууд өөрсдөдөө дэндүү хариуцлагагүй хандаж байгаагийн нэг илрэл бөлгөө. Түүнээс гадна Хятадын гурван том салбарын харьцаа төдийлөн зохистой бус буюу нэг, хоёр, гуравдугаар үйлдвэрлэлийн салбарын хувь хэмжээ 10:46:44 гэсэн харьцаатай байна. Өөрөөр хэлбэл манай үйлчилгээний салбарын эзлэх хувь хэмжээ дөнгөж 44 хувьтай байгаа нь дэндүү бага үзүүлэлт бөгөөд өрнөдийн хөгжингүй улсуудад бол 70-аас дээш хувьтай байдаг билээ. Түүнээс гадна хятадын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгалын түвшингийн дээшлэлт харьцангуй удаан төдийгүй тус улсын боловсролын салбарт зарцуулж байгаа хувь хэмжээ дэлхийн дунжийн дөнгөж 4 хувьтай тэнцэж байгааг бид улам дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хятад улсын нутаг дэвсгэрийн хэмжээ өргөн уудам болохоор бүс нутгуудын хөгжил харилцан тэнцвэртэй бус байдаг. Тухайлбал Шанхай хотын хүнам тутамд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хувь хэмжээ Гүйжоу мужийнхаас дөрөв дахин их байгаа нь дэндүү их зөрүүтэй гэсэн хэрэг юм. Хятадын аж үйлдвэр нь эрчим хүчинд хэт үрэлгэн ханддаг. Тухайлбал: Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ дэлхийн хэмжээний 9,5 хувийг эзэлдэг атал дэлхийн хэмжээнд зарцуулж байгаа цемент, ган, нүүрсний хэрэглээний тавин хувь нь зөвхөн хятад улсад ногдож байна. Бид Монголоос ч гэсэн ихээхэн хэмжээний нүүрс худалдан аваад хайлуулсан гангаа гадаадад экспортлож байгаа боловч бохирдсон агаар нь харин хятадад үлдэж байгаа нь ухаалаг хэрэг огт бус аа. Хятад улс боловсруулах үйлдвэрлэлээ ч өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал Америкад зориулан гаргадаг iPhone 4 – ийн Америкийн зах зээл дээрх жижиглэнгийн үнэ нь 499 доллар байдаг. Гэтэл тэр их ашгаас дөнгөж 12 доллар нь хятад улсад угсарсан болон ажилчдын цалин зэрэг зардалд үлдэж байгааг бодолцон иймэрхүү анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг аль болохуйц багасгах шаардлагатай байна. Ажил эрхлэлтийн талаар хэдэн үг хэлье. Одоо Хятад улсын хотжих үйл явцыг дагалдаад жил болгон 15 сая гаруй хөдөө тосгоны хүмүүс хотод шилжин ирж байгаа болохоор тэдний орон байр, ажил эрхлэлт болон эмчилгээг хариуцна гэдэг маш хүнд хэрэг болж байна. Өнөө жилийн тухайд 7 сая гаруй хүн их дээд сургуулийг төгссөн болохоор тэднийг нэг хоёр

жилийн дотор ажлын байраар хангах явдал мөн л засгийн газрын үүрэг юм. Хятадын ажилгүйдлийн статистик зөвхөн хот суурингаар л хязгаарлагддаг. Хөдөө тосгоны хүн амын тухайд газартай эсэхээр яригдах болохоор яг таг ажилгүй хүн гэж хэлэхэд бэрхтэй. Харин хот суурингийн ажилгүйдлийн хэмжээ 4-9 хувьд хэлбэлздэг бөгөөд өөрөөр хэлбэл дөрвөн хувь нь л идэвхитэй ажил хайж холбогдох байгууллагад бүртгүүлдэг гэсэн үг юм. Харин үлдсэн бүртгүүлээгүй хувьд хамрагдах хүмүүс нь ажил хийх дургүй буюу эцэг эхийнхээ гарыг харан идэж уучихаад хэвтэж байдаг урагшгүй залуус байдаг ажээ. Хотын хүн амын тулгарч байгаа хамгийн том асуудал бол байрны үнэ дэндүү өндөр байгаа явдал болж байна. Сүүлийн гучин таван жилийн хугацаанд нэг хятад хүнд оногдох сууцны талбайн хэмжээ 7 ам метрээс 35 ам метр боллоо өссөн нь харьцангуй үзүүлэлт л дээ. Гэвч байрны үнэ дэндүү өндөр болохоор их дээд сургууль төгсөгч зөвхөн өөрийнхөө орлогоор байр авна гэвэл маш хэцүү байх болно. Тийм учир шинэ өөрчлөлтийн бодлогоор засгийн газраас хямд өртөгтэй байр сууцыг бариад орлого багатай хүмүүст хямд үнээр түрээслэх буюу худалдах бодлогыг баримтлаж байна. Жил болгон тиймэрхүү хямд өртөгтэй барилга 10 сая ам метрийг барьж байгаа юм.

Одоо бидний өмнө тулгарч байгаа өөр нэг том асуудал гэвэл засгийн газрын хариуцаж байгаа эдийн засгийн асуудал дэндүү олон байна. Хятад улс үндсэндээ зах зээлийн эдийн засгийг байгуулж чадсан боловч эдийн засгийн чадалтай боловсон хүчний тоо хангалтгүй. Тэр ч байтугай бизнесмэнүүд өөрсдийн үйлдвэрлэл дээр хүртэл алдаа мадагтай ажиллах нь цөөнгүй байгаа учраас засгийн газрын оролцоо дэмжлэг зайлшгүй шаардлагатай байх үе тохиосоор байгаа юм. Өөр нэгэн ноцтой асуудал бол зарим албан тушаалтнууд авилга хээл хахуульд холбогдож байна. Хятад улс нь авилгачдыг шийтгэх тал дээр дэлхийн хамгийн хатуу чанга бодлоготой улсын тоонд орж байгаа. Энэ удаагийн удирдах бүрэлдхүүн авилга хээл хахуулийн эсрэг шийдвэртэй тэмцэх шийдвэр зориг төгс байгаа болохоор ямар ч байр суурь, урьдын түүхтэй байлаа гэсэн хуулийн дагуу асуудлыг шийдэхээр болж байна. Тийм болохоор харьцангуй богино хугацааны дотор дээрхи байдал нааштай засрах төлөв бий.



Би эхнээсээ авахуулаад л хятадын амжилтыг тоочоод уналгүй асуудлаа ярьж байгаа нь өөрийн хөрш орон та бүхэнд манай улсын асуудал хоёр талтай юм шүү гэдгийг илэн далангүй ойлгуулах гэсэн хэрэг. Өөрөөр хэлбэл сайн сайхан амжилтын хажуугаар саар муу зүйл ч байна. Гуравдугаар бүгд хурал дээр дурьдсан асуудлууд дээр үндэслээд өнөөдрийн шинэ өндөрлөгөөс илүү гүн гүнзгий өөрчлөлтийг хийхээр шийдсэн хэрэг. Одоо гучин таван жилийнхээс өөр нь юу гэвэл манай Хятад улс өөдлөн сэргэж байгаа харьцангуй баян чинээлэг орон болон хувирлаа. Тийм болохоор бид урьд өмнөх шигээ юм бүхэн дээр үндэсний нийт бүтээгдэхүүний өсөлтийг л цорын ганц хэмжих үзүүлэлт болгоод байж болохгүй юм. Өөрөөр хэлбэл үндэсний нийт бүтээгдэхүүний өсөлтийг дээдлэх үзлийг хэрэгжүүлэхгүй гэсэн үг.

Урьд нь бид эдийн засгийн хөгжлийг гол болгоод бусад талын хөгжлийг зэрэг харгалзаад явдаг байсан бол үүнээс хойш тогтвортой хөгжлийг дэвшүүлэн тавьж байгаа юм. Эдгээр өөрчлөлтийн дотор эдийн засаг, улс төр, соёл, нийгэм, амь ахуй болон намын байгуулалтын шинэчлэл багтаж байгаа болохоор хамрах цар хүрээний хувьд урьд өмнө байгаагүй их далайцтайн зэрэгцээ нэгэн зэрэг хэрэгжүүлэхээр болсон нь амаргүй зорилт юм. Автомашинтай зүйрлэн хэлэх юм бол түүнийг явуулахын хажуугаар засвар үйлчилгээ хийж, эд ангийг нь солиод онхолдуулалгүй, зогсоочихгүй байгаатай адил хэрэг юм.

Энэ үед хятадууд төдийгүй, гадаадынхан ч гэсэн "Хятад аль зүг замнаад ямар зорилгод хүрэх гээд байгаа юм бэ?" гэж асуух нь бий. Манай намын ерөнхий нарийн бичгийн дарга, улсын тэргүүн Си Зиньпин түүний хариуд "Бид хятад мөрөөдлийг хэрэгжүүлэх гэж байна" хэмээн хариулсан. Хятад мөрөөдөл гэдгийг нэг үгээр хэлэх юм бол дундад үндэстний аугаа их сэргэн мандалт юм. Энэхүү мөрөөдөл гагц өнөөдөр буй болчихсон зүйл биш л дээ. Бүр зуу гаруй жилийн өмнө анх үүссэн түүхтэй. Харин түүнийг улсын удирдагчийн зүгээс улс төрийн хөтөлбөр болгон дэвшүүлэн тавьж байгаа нь анх удаагийн хэрэг юм. Тийм болохоор нийгэм болон олон улсын түвшинд ихээхэн анхаарал татаж байна. Бидний ойрын үеийн зорилт гэвэл 2020 он гэхэд үндэсний нийт бүтээгдэхүүн болон

иргэдийн орлогыг 2010 оны үеийнхээс хоёр дахин нэмэгдүүлэх болно. Бид тэрхүү нийгмийг чинээлэг нийгэм хэмээн нэрлэж байгаа бөгөөд бүгдээрээ сайн сайхан амьдрах боломжтой гэсэн үг. Харин энэ зууны дунд үе буюу улс байгуулагдсаны 100 жилийн ой гэхэд бид бүхэн хүчирхэг, ардчилсан, дунд зэргийн хөгжингүй улс болсон байх зорилт дэвшүүлж байна. Зарим гадаадын анд нөхдүүд биднээс бас "Танай дундад үндэстний аугаа их сэргэн мандалт нь гадаадынхны хувьд юу гэсэн үг вэ?" гэж асуудаг.

Миний санаж байгаагаар бүр арваад жилийн өмнө буюу 2002 онд манай намын 16 дугаар их хурлаас дундад үндэстний аугаа их сэргэн мандалт хэмээн дурьдсан нь бий. Японы голлох хэвлэл мэдээллийн хэрэгслийн тэргүүн өгүүлэл бичдэг чадалтай сэтгүүлчдээс бүрэлдсэн төлөөлөгчид манай оронд айлчлах явцдаа надаас "Дундад үндэстний сэргэн мандалт нь манай япончуудын хувьд ямар утгатай вэ? Та нар Тан улс шигээ болох юм уу? Эсвэл Хань улс шиг болох гээд байна уу?" хэмээн асууж байсан. Бас Өмнөд Солонгосын албаны хүмүүс ч надаас бас "Та нар сэргэн мандчихвал бид яах болж байна вэ? Та нар бол том улс, харин бид нар жижиг улс шүү дээ?" хэмээн асууж байсан удаатай. Тэдний хувьд жаахан эндүү төөрөгдөлд автаад байх шиг санагддаг юм. Бидний хэл яриа ч жаахан шинжлэх ухаан талдаа, ерөнхий тойм байж мэдэх учраас энд жаахан тодруулга өгье гэж бодлоо. Хятад хэл нь англи хэлийг бодох юм бол илүү товч тодорхой байдаг л даа. Бид өөрсдийн дээр өгүүлсэн мөрөөдлийг англи хэл рүү «chinese dream» хэмээн буулгадаг боловч европ, америкчууд харин түүнийг «chinese dream» гэхгүй «china dream» гэж буулгаад байдаг. Энэ хоёр бол тун ялгаатай ухагдахуун юм шүү. Одоо Америкад амьдарч байгаа нэг англи эрдэмтэн тэнд нэг ном гаргасан байсан л даа. «china dream» гэсэн гарчигтай юм байна лээ.

Түүний дэд гарчиг нь "Дэлхий дээрхи хамгийн сүүлчийн бүрэн нээгдээгүй том зах зээл" гэсний зэрэгцээ «Хятад хүн долоо хоногт юм уу, эсвэл нэг хоногт нэг лааз кока кола уугаад байхад Кока кола корпораци хэдий хэрийн ашиг олох вэ?» гэх зэргээр бичсэн байсан. Япончууд ч гэсэн биднээс урьд нь та нар дижитал зургийн аппарат авахдаа энгийн

нь сонгодог байсан. Харин одоо дан дурантай EOS зэрэг том зургийн аппарат авах уу гэж асуудаг. Би тэдэнд хэрвээ «chinese dream» хэрэгжчихгүй юм бол «china dream»-д ихээхэн өргөн уудам орон зай буй болох юм шүү. Тэр хэрээр гадаадынхан ч их ашиг хүртэх болно гэж хариулдаг.

Ойрын арван жилд бид гадаадаас авах бүтээгдэхүүнд 1 их наяд доллар зарцуулах төлөвтэй байгаа. Жил болгон зуу гаруй сая хятад хүн гадагш жуулчлалаар явдаг боллоо. Энэ удаагийн өөрчлөлт шинэчлэлийн гол цөм нь зах зээлийн эдийн засгийн болон эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм. Ингэснээр өөрчлөлт шинэчлэлийг бүх талаар гүнзгийрүүлэх үйл явцын суурийг бий болгоно. Түүний дотор шударга, нээлттэй, ил тод зах зээлийн дүрмийг тогтоож, орон нутгийн хувиа хичээх үзэл, монопол, шударга бус өрсөлдөөн зэргийг эсэргүүцэн, нийгмийн итгэлцлийн тогтолцоог буй болгох юм. Хятад улс нь өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлэхээс өмнө хувийн аж ахуй гэх зүйл бараг үгүй болчихоод байсан.

Гэтэл одоо хувийн сектор татвар бүрдүүлэлтийн тавин хувь, үндэсний нийт бүтээгдхүүний 60 гаруй хувийг буй болгож байгаагийн зэрэгцээ ажил эрхлэлтийн 80 хувь нь чухам энэ салбарт ногдож байгаа билээ. Тийм болохоор манай хятад улс цаашдаа өмчийн олон хэлбэрийг хамгаалан хөгжүүлж, улсын бус секторыг гадуурхан үздэг явдлыг арилгах болно. Энд онцлох ёстой нэг зүйл гэвэл улсын үйлдвэрийн газарт хувийн хөрөнгө оруулалт хийж, тодорхой хэмжээний хувьцаа эзэмших явдлыг зөвшөөрдөг боллоо. Ингэснээр улсын үйлдвэрийн газрын ил тод байдлыг хангаж, тэндэхийн ажилчин албан хаагчид ч хувьцаа эзэмших эрх нээгдэж байгаа юм.

Хятад зарим хүмүүс улсын секторыг шүүмжлэх нь байдаг л даа. Тухайлбал тэднийг улсаас харж үзээд зээл хөөцөлдөхөд амар байна ч гэдэг юм уу, эсвэл улсын үйлдвэрийн газрын удирдлагын цалин хөлс дэндүү өндөр хэмээн шүүмжилдэг. Тухайлбал боловсрол чадварын хувьд өөртэй нь бараг ижил шахам хүн улсын үйлдвэрийн газарт очихоороо орлого нь хэдэн арав дахин ихсээд байвал нөгөөгийнх нь сэтгэл яаж амар байх билээ? Нэг нь сайд, нөгөө нь захирал хийлээ гээд адилхан л ядарч таарна биз дээ? Татвар тушаасны дараа

тэдний орлого хаашаа алга болчихдог хэрэг вэ? Сайндаа л 5-10 хувийг нь улсад тушааж байгаа биз дээ гэх нь ч олонтоо байсан. Тийм болохоор улсаас тэдний татварыг 30 хүртэл хувь нэмэгдүүлэхээр шийдсэн юм. Мэдээж өөдөөс нь хэцүү байна гэж халаглах нь ойлгомжтой. Хэцүү байсан ч тушаахаас өөр яалтай билээ. Тийм болохоор эхлээд 10 хувь, 15 хувь, 20 хувь гэх мэт нэмсээр одоо 30 хувь болгож байгаа нь тэр юм.

Банк санхүүгийн хувьд ардын зоос олон улсын чанартай валют болоход тодорхой үе шат хэрэгтэй. Одоогийн шатанд ардын зоосны зах зээлийн үнэ ханшийг банк тогтоох бус харин зах зээлийн горимоор тогтоож байвал зүйтэй юм. Түүнээс гадна хот хөдөөгийн хоёр туйлт тогтолцоо бол манай хотжих үйл явцад тулгарч байгаа гол бэрхшээл юм. Түүнийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай. 35 жилийн өмнө манай хотжилтын түвшин 18 хувьтай байсан бол одоо тавин нэгэн хувь руу дөхөөд байна. Ойрын жилүүдэд жилдээ нэг пунктээр нэмэгдэж байгаа буюу 13 сая хүн хот руу шилжин суурьшиж байгаа юм. Бид хотуудад ядуусын хороолол буй болгож хот руу орж ирсэн тариачдын хүүхэд сурах сургуульгүй байлгаж болохгүй. Өөрөөр хэлбэл хотын уугуул иргэд болон шинээр шилжин ирэгсэд адилхан хангамж эдэлдэг нөхцлийг буй болгохын тулд засгийн газраас чамгүй хүчин чармайлт гаргах шаардлагатай юм.

Хятадын өөрчлөлт шинэчлэлийн ахиц олоход дэлхийн нийтийн тус дэм маш их байсан. Өөрөөр хэлбэл ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт болон гадаадын техник тоноглол орж ирсэн нь манай өөрчлөлт шинэчлэл түргэн хурдацтай хөгжихийн үндсэн шалтгааны нэг байсан. Өнөөг болтол бид гадаадаас 1 их наяд 300 тэрбум долларын хөрөнгө оруулж ирсэн нь Өмнөд Солонгос, Энэтхэг болон Японтой харьцуулахад их л зоримог хөдөлсөн хэрэг юм. Нөгөө талаар бидний нээлттэй байгаа түвшин ч тэднээс хавьгүй өндөр болохыг харуулж байгаа үзүүлэлт л дээ. Тухайлбал Энэтхэг улс жижиглэн худалдаа болон супермаркетийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхийг хориглодог бол манай улсад чөлөөтэй байдаг. Түүнээс гадна манай Хятад улсад гадаадын 30 гаруй банк үйл ажиллагаагаа явуулдаг бол бусад улсуудад ийм чөлөөтэй байдал үгүй байна.

Би өөрчлөлт шинэчлэлийн бүхий л үйл явцад гар бие оролцсон тухай дээр өгүүлж байсан. Дээрх санаанууд анх дэвшигдэн тавигдаж байх үед манай улсын дотоодод ч цөөнгүй хүн тийм алхмыг эсэргүүцэж байлаа. Өөрөөр хэлбэл тийм арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь улс орны хувь заяанд хариуцлагагүй хандсан хэрэг бөгөөд яваандаа гадаадын хөрөнгө оруулалтын хяналтад орчих вий хэмээн маш их цэрвэдэг байлаа. Тухайлбал газрыг 50 болон 70 жилээр гадаадын хүмүүст түрээсээр эзэмшүүлэх нь улс орноо худалдсан хэрэг биш гэж үү гэж нь ч байв.

Тэр бүхний хариулт уг нь их энгийн л дээ. Гадаадынхан хятадын газар нутгийг түрээсэлж аваад үйлдвэр байгуулж, хятадын хууль дүрмээр үйл ажиллагаагаа явуулахад улс орноо худалдсан асуудал хаанаас гарах билээ? Шанхай хотын Пудунгийн чөлөөт бүсэд би төлөвлөлт хэрэгжилтийн асуудал хариуцдаг байлаа. Тухайн үед гадаадын олон арван барилгын компаниуд хүрэлцэн ирж тэнгэр баганадсан барилга барьдаг байв. Нэг япон бизнесмэн нэг тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалт хийж 310 мянган ам метр талбай бүхий 495 метр өндөр барилга барьсан юм.

Япончуудаар ийм өндөр барилга бариулж болж байгаа юм уу гэж асуух хүн тэр үед цөөнгүй байлаа. Яагаад болдоггүй юм бэ? Тэгээд л барьж гүйцсэн хойно тун ашигтай ажиллаад хоёр талд чамгүй орлого оруулж байгаа шүү. Нэг гэм нь бороо орж байгаа өдөр дээр суудаг хүмүүс доод давхарт бороо орж байгаа болов уу? Шүхрээ авах хэрэгтэй юу хэмээн доод давхарт ажиллаж байгаа найз нөхдөөсөө асуудаг гэсэн. Энэ удаа өөрчлөлт шинэчлэлийг улам бүр урагшлуулахын тулд 35 жилийн туршид хэрэгжиж ирсэн холбогдох хууль тогтоомж болон тогтолцоог үндсээр нь өөрчлөх хэрэгтэй байгаа юм.

Энэ нь мэдээж амар хялбар хэрэг бишийн дээр их л хашир болгоомжтой хандах хэрэгтэй. Мэдээжийн хэрэг муужруулах аргыг хэрэглэж болохгүй. Гагцхүү зоримог атлаа хашир аргыг сайтар хослуулах учиртай юм. Шанхай хот бол манай хятадын хувьд хамгийн олон улсын жишигт нийцсэн газар болохоор энэ удаагийн туршилт мөн л эндээс эхтэй байгаа нь санамсаргүй хэрэг биш. Тийм болохоор тэнд Хятадын чөлөөт худалдааны бүс FTZ-ийг байгуулж эхлээ. Би

Шанхай хотын орлогч даргаар ажиллаж байхдаа Пудунгийн нээлттэй бүсийг хариуцаж байсан. Тэнд мөн л чөлөөт худалдааны бүсийг байгуулж байсан боловч хараахан олон улсын түвшин хүрээгүй болохоор цар хүрээ ажил үүргийн хувьд хязгаарлагдмал талтай байлаа. Харин энэ удаа Шанхай хотноо байгуулагдаж байгаа чөлөөт худалдааны бүс нь урьд өмнө хятадын хаана ч байгаагүй чанарын эрс ялгаатай бүтэц юм.

Шанхай хотод урьд нь байгуулагдсан чөлөөт худалдааны бүс нь хятадаа анхных төдийгүй хамгийн сайн ажиллаж, ашиг орлого, татвар бүрдүүлэлтээр ч тун сайн байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ л худалдаа, хөрөнгө оруулалт, банк санхүүгийн бүрэн чөлөөт байдлыг хараахан хангаж чадахгүй байсан юм. Тийм болохоор энэхүү шинэ чөлөөт худалдааны бүс нь өөрчлөлт нээлттэй бодлогын чиг шугамын туршилтыг гүйцэтгэж, шинэ туршлага хуримтлуулан, шинэ шинэ хууль дүрэм боловсруулж байгаа болохоор урьд нь хэрэгжиж байсан хуучин хууль тогтоомжууд тэнд түр хэрэглэгдэхээ байсан зэрэг маш их эрх чөлөөг олгож байна. Урьд нь зөвхөн барааны арилжаа явуулдаг байсан бол одоо үйлчилгээний арилжаа явагдахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын болон боомтын гаднах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч байна.

Урьд нь хятадын хууль тогтоомжийн дагуу хийж болох зүйлсийн тухай маш урт жагсаалт гаргачихсан байдаг нь гадаадын хөрөнгө оруулагч нарт зарим талаар төвөгтэй санагддаг байсан байж мэдэх юм. Харин одоо хориотой үйл ажиллагааны жагсаалт гэгчийг гаргаад түүнээс бусад салбарын үйл ажиллагааны тухайд гэвэл бүртгүүлээд л ажлаа эхлэх боломжтой болсон. Одоогийн байдлаар уг жагсаалтад 18 төрлийн хориотой зүйлс байгаа бөгөөд жил ирэх тусам улам цөөрөх хандлагатай байна. Одоо гадаад дотоодын бизнес эрхлэгчид тэнд компаниа бүртгүүлэх буюу нэг жижиг газар худалдаж аваад үндсэндээ болчихож байгаа болохоор бүгдээрээ л тэндэхийн ахиц дэвшлийг анхааралтай ажиглан харах болов. Та бүхэн ч гэсэн Шанхай хотод хүрэлцэн очоод Пудунгийн шинэ бүсийн хөгжлийн байдал болон ажил хэргийн байдалтай танилцах зуур санаа оноогоо харамгүй нэмэрлээрэй гэдэг санал тавьж байна. Тэнд агаарын боомтын

чөлөөт худалдааны бүс, гүний усны чөлөөт худалдааны бүс болон бараа солилцооны боомтын чөлөөт худалдааны бүс зэрэг байдаг. Та бүхэн тэнд очно гэвэл би дуртайяа хамт явахад бэлэн байна. Шанхай хотод ч сайн монгол хэлний орчуулагч байдаг боловч өөрсдийнхөө орчуулагчийг аваад очвол илүү найдвартай байх шүү. Өчигдөр манай онгоц нэг цаг дөчин минут нисээд л наашаа хүрээд ирсэн нь дэндүү ойрхон зайтай байгааг харуулж байна. Дээр нь цагийн зөрүү байхгүй. Би уг нь та бүхнийг Шанхайн агаарын бохирдлоос жаахан цэрвэх байх гэж эмээж байсан юм. Гэвч энд ирсэн хойно танайд ч агаар бас л тааруу байдгийг үзээд тэр айдас маань одоо үгүй боллоо. Хэрвээ энд хямд төсөр агаад шүүлтүүртэй амны хаалт хийгээд зарвал боломжийн мөнгө олж болно шүү хэмээн ярьж байсан.

Энэ удаагийн бүтд хурлын шийдвэр нь гадаадын хөрөнгө оруулалтад нааштай хандахын зэрэгцээ хятадын үйлдвэрийн газрууд ч гадаадад хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж байгаагаараа урьд өмнө байгаагүй онцлогтой юм. Урьд нь хятад улс гадаадад хөрөнгө оруулалт хийхийг төдийлөн дэмждэггүй, валютын хязгаарлалттай байсан бол одоо манай улсын валютын нөөц 3 их наяд 600 тэрбум америк доллар болсон тул нэг бодлын ихээхэн дарамт учруулж байгаа гэсэн үг юм. Арга буюу америк болон европын бондыг худалдан авч байна. Америк долларын хувьд олноор үйлдвэрлэх бодлого баримталж байгаа болохоор байнга ханш нь унаж байна. Тийм болохоор мөнгөө буцаагаад аваад ирэхэд хүү гэх юм байхгүй байгаа хэр нь америкчууд ч тэтгэлээ их таатай хандахгүй байгаа юм. Улсын эрх ашгийн үүднээс авч үзэх юм бол хятадын үйлдвэрүүд тэр мөнгийг аваад гадаадад хөрөнгө оруулалт хийвэл хамгийн ашигтай бөгөөд түүнийг «хилийн дээс алхах бодлого» хэмээн нэрлэдэг болов.

Хятадын үндэсний нийт бүтээгдэхүүн дэлхийд эзлэх хувь хэмжээ 9,5 хувьтай байгаа мөртлөө дэлхийн хөрөнгө оруулалтын дөнгөж 3,2 хувийг эзлэж байгаа нь дэндүү чамлалттай үзүүлэлт мөн. Харин өнгөрсөн жилийн тухайд гадаадад хийх хөрөнгө оруулалт 17 хувиар өслөө. Энэ янзаараа байвал дэлхийн зах зээлд эзлэх хөрөнгө оруулалтын хувь хэмжээ ойрын таван жилд 6 хувьд хүрэх найдлага байна.

Би хятадын бизнесмэнүүдэд хичээл зааж байх үедээ та бүхэн гадаадад хөрөнгө оруулахдаа тухайн улсын хууль тогтоомж болон үндэсний зан заншлыг хүндлэхээс гадна нийгмийн хариуцлагатай бизнес эрхлээрэй гэж байнга зөвлөдөг. Тэд хариуд нь бид сургуульд мөнгө хандивласан шүү дээ гэх нь бий. Асуудал тэгээд л гүйцчих зүйл огт биш ээ.

Ажилчдын эрх ашгийг сахин хангах, үйлдвэрчний эвлэлтэй үг хэлээ ололцох, парламенттай холбоо тогтоож, тэдний тавьсан асуултанд хариулах гээд олон хариуцлага байгаа. Хятадын тухайд гэвэл захиалга олж чадсан босс нь ажилчдадаа илүү цагаар сайн ажиллаарай. Цалинг чинь гурав дахин нэмлээ шүү гэж хэлэх нь бий. Харин гадаадад тэгж болохгүй. Италичууд илүү цагаар ажиллана гэж юу байсан юм бэ? Амралт л хамгийн чухал биз дээ гэлцдэг. Өрнөдийнхөн засгийн газар нийгмийн халамжийг бууруулж болохгүй, харин гадаадын компаниуд бидэнд хамгийн өндөр цалин өгөх ёстой. Эс бөгөөс бид жагслаа шүү гэж айлгадаг. Европчууд болон Латин америкчууд манай азийнхнаас эрс ялгаатай л даа. Азийнхан бол ажилч хичээнгүй, арвич хямгач зантай. Дээр нь олсон мөнгөө үр хүүхдэдээ үлдээх гэдэг. Харин нөгөөдүүл бол олсон зөөснөө үрж зараад л дуусгах нь тэр. НҮБ-д үйлдвэрийн газрын нийгмийн хариуцлагын ISO26000 гэдэг стандарт байдаг. Тэр хэдийгээр хуульчилсан зүйл биш зөвлөмж маягтай зүйл боловч манай хятадын бизнесмэнүүд их сонирхож байгаа.

Бид нар одоо Монгол, Өмнөд Солонгос болон Япончуудтай хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг хурдасгаж байгаагийн зэрэгцээ олон талт чөлөөт худалдааны бүс байгуулах боломжтой. Манай Хятадад зүүн хойд ази гээд ярихаар Монгол улсыг орхигдуулдаггүй. Учир нь Монгол бол тус бүс нутгийн чухал бүрэлдхүүн хэсэг болохоор тэр юм. Гэхдээ ний нуугүй хэлэхэд бидэнд чамгүй төвөгтэй асуудал үүсээд байгаа нь японтой тогтоосон харилцаан дээр илэрч байна. Дэлхийн хоёрдугаар дайны үеэр япончуудад алуулж, өлсгөлөнгөөр үхсэн хүний тоо манай хятадад 30 сая хүрсэн юм шүү. Гэсэн атал манай хятадууд тэдэнд дайны төлбөр авахаа байя даа. Учир нь тэр дайны японы милитаристууд өдөөсөн болохоос биш японы ард түмэн буруутгүй гэж хэлээд өнгөрөөж байсан удаатай.

Хятад Японы хооронд дипломат харилцаа сэргээгээд 40 жил болоход эхний хорин жил нь тун боломжийн байсан. Тэр үед японы тэнгэрлэг эзэн хаан ч манай хятадад айлчилж байлаа. Харин одоо их төвөгтэй байдал үүсээд байна. Юуны өмнө газар нутгийн маргаантай асуудал буюу Дяо Юй Дао арлын байдлыг ярих хэрэгтэй. Дэлхийн хоёрдугаар дайны дараах үеийн бичиг баримт болон олон улсын шүүхийн шийдвэрт ч хятадын нутаг дэвсгэр гээд заачихсан байдаг юм. Гэсэн атал бид тэр асуудал дээр маргалдаад яах вэ? Дараа тухтай хэлэлцье гэдэг боловч япончууд түүнийг улсын мэдэлд оруулж өөрийн нутаг дэвсгэр мэт харуулах гээд байх болов. Одоо тэд нар түрэмгийлэл гэж чухам юу болох талаар олон улсын хэмжээнд тогтсон ухагдахуун байхгүй.

Солонгосын эзэлж байсан нь түрэмгийлэл биш гэж яриад байгаа болохоор японы удирдагчдад итгэх итгэлийг сулруулж хэлэлцээр хийхэд хүндрэл учруулаад байна. Байдал хэдийгээр ийм байгаа боловч бид нар япончуудыг дайсагнан үзэлгүй ултай хэлэлцээр хийсээр байна. Тэд нар бидний хөрш бөгөөд хүн хөршөө сонгодоггүй. Харин сонгож болох зүйл гэвэл хандлага байдаг болохоор японы ард түмэнд аль болохуйц найрсаг хандахыг хичээж байна. Тийм болохоор манай засгийн газар хятадын ард түмний японы эсрэг үзлийг дэвэргэхгүй байгаа юм. Харин түрэмгийллийн түүхийг хүлээн зөвшөөрдөггүй цөөн тооны хэт барууны хүчинг нь л эсэргүүцэж байдаг. Цаг боломжоос шалтгаалаад олон улсын асуудлаар ярих сэдвээ үүгээр дуусгавар болгоё. Хэдийгээр энд олон улс судлалын мэргэжилтэнгүүд цугларсан боловч даанч цаг алга болохоор яая гэхэв.

Дотоод улс төрийн тогтолцооны асуудлаар бидний хийх ажил гэвэл социалист ардчиллыг улам бүр эрүүлжүүлж, улс төрийн зөвшилцлийг бэхжүүлэн, зөвшилцлийн хамрах хүрээг өргөтгөж, олон нийтийн зүгээс төрийн хэргийг хэлэлцэхэд оролцох идэвхи санаачлагыг урамшуулан, прокурор шүүхийн тогтолцоог бэхжүүлснээр цаазаар авах ялыг аль болох багасгах чиглэлийг баримтлаж байна. Гэхдээ энэ бүхнийг алхам алхмаар хэрэгжүүлэх нь ойлгомжтой юм. Та бүхэн өнөөдрийн ярианаас өөрчлөлт шинэчлэлийн цар хүрээ маш том болохыг ойлгосон буй за. Тийм болохоор өөрчлөлтийн явцад олон

түмний санаа бодол, гадаад ертөнц тэр дундаа хөрш зэргэлдээ орнуудын санаа бодлыг сонсож байхын зэрэгцээ өөрсдийн арга барилаа ч байнга өөрчлөн шинэчилж байх учиртай юм. Бидний өөрчлөлт монголчуудад нэгийг бодуулахын хэрээр хамтын ажиллагаа маань улам бэхжих нь дамжиггүй. Монгол гэдэг үг манай хятадуудад их л дотно сонсогддог нэр үг юм. Та нар бол манай хөрш зэргэлдээ улс төдийгүй манай хятадад ч маш олон монгол үндэстэн ахан дүүс чинь амьдран суудаг. Тийм болохоор бид газарзүйн байршил болон соёлын хэлхээ холбоо зэргийг бодолцож үзсэн ч харилцаан дээр ямар нэгэн асуудал болон саад тогтор байх учиргүй. Манай хятадад «Усанд ойрхон асрын тагтнаас сарыг түрүүлж хардаг» гэсэн мэргэн үг байдаг. Өөрөөр хэлбэл усанд ойр байх аваас сарны гэрлийн ойлтыг харж болно гэсэн үг юм л даа. Тэр хэрээр сар чамд ойртож байгаа хэрэг.

Хятад Монгол хоёр орон ойр зэргэлдээ хөрш болохоор бидний эрх ашиг харилцан нөхөрлөх нь гарцаагүй юм. Монгол улс болоод Монголтой тогтоосон найрамдалдаа хүндэтгэлтэй хандах нь хятадын эрх ашигт нийцэх бөгөөд бид найрсаг хөршүүд болохоор ойр зуурын эрх ашиг биш өнө холын эрх ашгийн тухай ярьж байгаа гэдгийг ойлгоно буй за. Хөршийг сонгодоггүй, харин хандлага, тэр дундаа найрсаг хандлагыг хүн сонгож болдог билээ.